

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



# 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 он

# АГУУЛГА

- Хүний нөөц
- Ил тод нээлттэй байдал
- Шинэ санаа бүтээлч байдал
- Бүртгэлийн тоон үзүүлэлт
- Санхүү үйлчилгээ
- Өргөдөл, гомдол
- Сургалт, хамтын ажиллагаа
- Эрүүл мэнд
- Бусад



# ЭРХЭМ ЗОРИЛГО

МОНГОЛ УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР  
“ИРГЭН ТӨВТЭЙ,  
ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ  
ТӨРИЙН  
ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЦОГЦЛООНО”



**ИРГЭН,ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛНЭ.**

## ХҮНИЙ НӨӨЦ:



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаалаар 30 орон тоо батлагдсан.



Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахаар Сити их сургуулийн эрх зүйн бакалаврын эчнээ ангид 2 албан хаагч суралцаж байна.


2026 оны эхний хагас жилийн байдлаар 1 албан хаагч шинээр томилогдож, 1 албан хаагч шилжин томилогдсон.

## ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ:

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүр [dornod.burtgel.gov.mn](http://dornod.burtgel.gov.mn), [facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) цахим хуудсанд нийтлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд бодлого шийдвэр, цахим үйлчилгээ, улсын бүртгэлийн хууль тогтоомж, цаг үе, үйл явдалтай холбоотой (e-Mongolia-н үйлчилгээ, Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл) 132 мэдээллийг байгууллагын [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn), [https://www.gov.mn/mn/organization/Dornod\\_Ulsiin\\_burtgel\\_kheltes#transparency](https://www.gov.mn/mn/organization/Dornod_Ulsiin_burtgel_kheltes#transparency) цахим сайт [www.facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) фейсбүүк /2569 дагагчтай/ хуудсаар тогтмол сурталчилж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 54 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9 дэх хэсгийн хэрэгжилтийг хангахаар шилэн индекс/[shilen.gov.mn](http://shilen.gov.mn)/-ийн тайланг улирал бүр гарган 100% үнэлүүлэв.



| # | Тайлант үе      | Хувиар | Төлөв       | Төгсөхийн өгөөж | Мэргэсэн харагч  | Бэлтгэгдсэн үргэлжлэх хувь | Бэлтгэл нэрлэгдсэн | Үндэс |
|---|-----------------|--------|-------------|-----------------|--|----------------------------|--------------------|-------|
| 1 | 2025 оны 4 үеэр | 1      | Гүйцэтгэсэн | 2025-11-07      |  | 0%                         |                    |       |
| 2 | 2025 оны 3 үеэр | 1      | Гүйцэтгэсэн | 2025-10-02      | <a href="mailto:s.khargvaal@dornod.gov.mn">s.khargvaal@dornod.gov.mn</a> | 100%                       | 3 НОРОО-НИ         |       |
| 3 | 2025 оны 2 үеэр | 1      | Гүйцэтгэсэн | 2025-07-04      | <a href="mailto:s.khargvaal@dornod.gov.mn">s.khargvaal@dornod.gov.mn</a> | 100%                       | 3 НОРОО-НИ         |       |
| 4 | 2025 оны 1 үеэр | 1      | Гүйцэтгэсэн | 2025-03-26      | <a href="mailto:s.khargvaal@dornod.gov.mn">s.khargvaal@dornod.gov.mn</a> | 99.67%                     | 3 НОРОО-НИ         |       |

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 23 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.3, 2024 оны 31 дүгээр хуралдааны тэмдэглэлээр төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас [/www.gov.mn/](http://www.gov.mn)-т мэдээ, мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчилж ажиллахыг даалгасан. Иймд хэлтсийн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас [/www.gov.mn/](http://www.gov.mn)-ыг 2025 оны 07 сарын 04-ний өдөр нээлгэн 2024 оноос эхлэн хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл болон нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн нээлттэй мэдээллүүдийг шинэчлэх, нөхөж байршуулан биелэлтийг хүргүүлэн ажилласан.

Байгууллагын “НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970” дугаараас иргэд бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авах боломжтой бөгөөд 05 дугаар сарын байдлаар 514 иргэнд үйлчлүүлсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний “ДӨТ” машинаар нийт 2652 иргэн (гэрлэсний бүртгэлийн, байнга оршин суугаа хаягийн, иргэний цахим үнэмлэхийн, эд хөрөнгөтэй эсэх) гэх мэт лавлагаа үйлчилгээг авсан байна.

“ГАДААД ПАСПОРТ ЗАХИАЛГЫН ЦАХИМ МАШИН”-аар 425 иргэн үндэсний энгийн цахим гадаад паспорт захиалсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох, үйлчилгээний төлбөр, хураамжийг боловсронгуй болгох зорилгоор “ГЭРЭГЭ” киоск машинаар 13160 иргэнд үйлчилсэн байна.

Ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж ажиллав.

#### АВЛИГА:

Авлигын талаарх мэдээллийг хүлээн авах тусгай дугаар шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт 8 сумын 22 мэдээллийн самбарт авлигыг мэдээлэх 11-10 дугаарыг байршуулж холбогдох мэдээллийг 2026.02.27-ны өдөр [s.enkhchimeg@burtgel.gov.mn](mailto:s.enkhchimeg@burtgel.gov.mn) цахим хаягаар хүргүүлсэн.

АТГ-ын албан ёсны цахим хуудсанд тавигдсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх уриалга бүхий 6 мэдээллийг байгууллагын цахим хуудас [dornod.burtgel.gov.mn](http://dornod.burtgel.gov.mn) сайт болон Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс фейсбүүк хуудасны дагагч болох 2569 иргэдэд түгээн сурталчлан ажиллав. 2026.01.14-ний өдөр захиргааны ахлах мэргэжилтэн М.Галбадрах Авлигатай тэмцэх газарт танхимаар сургалтад хамрагдсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Шүгэл үлээгч” постерийг бэлтгэн 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын цахим хуудсанд түгээн сурталчлан ажилласан.



Хэлтсийн 22 албан хаагчдад хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглөх зааварчилгаа, зөвлөмжийг өгч 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар хүлээн авч баталгаажуулсан. Мөн шинээр томилогдсон 1 албан хаагчийн ХАСХОМ-ийг бөглүүлж баталгаажуулсан.

## ШИНЭ САНАА, БҮТЭЭЛЧ АЖИЛ:


“ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ” ВИДЕО МЭДЭЭЛЭЛ ЦУВРАЛААР ХҮРГЭЖ АЖИЛЛАЛАА.

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэхээс гадна Улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Та үүнийг мэдэх үү” видео мэдээ, мэдээллийг цувралаар хүргэн ажиллаж байна. Үүнд:

1. E-mongolia-аас төрсний бүртгэлийн лавлагааг 4 улсын хэлээр авах тухай. 1.5К үзэлттэй.
2. E-mongolia-аас гэрлэлтийн бүртгэлийн лавлагааг 4 улсын хэлээр авах тухай. 3.3К үзэлттэй.
3. E-mongolia-аас иргэний цахим үнэмлэхийн лавлагааг 4 улсын хэлээр авах тухай. 1.3К үзэлттэй.
4. E-business-ээр Төрийн бус байгууллагын тайлан илгээх заавар. 3.3К үзэлттэй.
5. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн “Гарт–Гэрт” бүртгэлийн үйлчилгээний талаарх хийсэн видео бичлэгийг 4,5К хүн тус тус үзэж, 146 хүн хуваалцаж бусдад түгээсэн байна. Бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болох [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn) сайт болон “Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд сурталчилж, мэдээлэл хүргэн ажилласан.



“Иргэндээ ээлтэй бүртгэлийн үйлчилгээ” аяны хүрээнд Халхгол сум, Хилийн цэргийн 0306 анги (Мэнэнгийн отряд), Халхгол сумын Ялалт багуудад 2025.05.27-29-ний өдрүүдэд ажиллаж 104 иргэнд зөөврийн төхөөрөмж ашиглан бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.





### АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА:

Албан хаагчдын ажиллах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн орчныг сайжруулах зорилгоор 1,171,500 төгрөгийн зардлаар 6 ширхэг сандал худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн байгууллагын архив В1 давхарт байрладаг бөгөөд авто машины утаа, дуу чимээ, тоосжилтоос хамгаалах зорилгоор тусгаарлах хаалгыг 898,000 төгрөгөөр хийлгэв.



Байгууллагын мэдээллийн самбарыг шинэчилж, үүдний ханын хэсгийг сэргээн будаж засварласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор дараах тоног төхөөрөмжийг шийдвэрлэж өгсөн. Үүнд:

- Суурин компьютер - 1 ширхэг
- Принтер - 1 ширхэг
- Зөөврийн компьютер - 1 ширхэг


Шинээр томилогдсон Дашбалбар сумын улсын бүртгэгчийг УБЕГазарт чиглүүлэх, ажлын байранд дадлагажуулах сургалтад хамруулсан.





## БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ:

Бичиг хэргийн эргэлт.



## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хэлтсийн даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу 2025 онд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн зөрчил илрүүлэн арилгах, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилтыг тавьж ажиллалаа.

Сумын улсын бүртгэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр танхимын сургалт зохион байгуулж, “Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл, чиглэл өгч ажилласан.



Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг нийт 1869 бүртгэлд хийв. Үүнээс: Иргэний улсын бүртгэл-318, Эд хөрөнгийн-559, Хуулийн этгээд-269, Архивын мэдээллийн удирдах программд цахимжуулсан-733 бүртгэлд хяналт шалгалтын ажиллагаа явуулахад 102 зөрчил илэрснээс 101 зөрчлийг тухай бүр арилгаж, 1 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган шийдвэрлэв.

Урьдчилсан хяналт шалгалт хийсэн бүртгэлийн тоо:



Бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдлийг хууль тогтоомжид заасан хугацаанд бүрэн ханган шийдвэрлэж нийт 65 дүгнэлтийг нотлох баримтад үндэслэн зөрчлийг арилгаж, тухай бүр мэдээллийн санд засвар өөрчлөлтийг тусгуулан ажиллав.

Хууль, захиргааны хэм хэмжээг актыг зөрчсөн нийт 44 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, зөрчлийн материалыг хуульд заасан хугацаанд прокурорт хянуулж, сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон тайлан мэдээг 5 удаа хүргүүлэн ажиллалаа.

#### ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ:

ИУБГ-аас 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 3/297 дугаарт “Нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэл шалгах тухай” чиглэлийн дагуу 2023, 2024, 2025 онуудад иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, нөхөн бүртгэсэн бүртгэлийг нэг бүрчлэн шалгаж илэрсэн зөрчлийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж илтгэх хуудсыг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.

УБЕГ-ын Тамгын газрын Эрх зүйн хэлтсээс 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1-2/15 дугаарт “Журам хүргүүлэх тухай” Иргэний улсын бүртгэгч нарыг салбар дундын хамтарсан багт байгууллагыг төлөөлөн ажиллах дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах талаар нийт улсын бүртгэгч нарт цахимаар танилцуулсан.

Төрийн албаны салбар зөвлөлөөс 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаарт “Судалгаанд хамруулах тухай “ Төрийн захиргааны албан хаагчдыг чадамжийн хэрэгцээ, өнөөгийн төлөв байдлыг судалгаанд 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр цахимаар хамрагдсан.


ИУБГ-аас 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 3/999 дугаарт “Иргэний бүртгэлийг баталгаажуулах тухай” чиглэлийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр сумын улсын бүртгэгчдэд онлайнгаар мэдээлэл, сургалт өгч илтгэх хуудсыг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр цахим шуудангаар хүргүүлэн ажилласан.

Тус сургалтыг танхимаар авах хүсэлт нийт сумын улсын бүртгэгч нар хэлтсийн даргад хүсэлт гаргасан тул 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хэлтсийн даргаар удирдамж батлуулан зохион байгуулсан. Бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг сумын улсын бүртгэгч нарт дотоод сүлжээ болон утсаар тогтмол өгч ажилласан. Хэлтсийн даргын дотоод албан бичгээр 2009-2010 оны төрсний бүртгэлийн дэвтрийг шүүн цахимжуулаагүй, нас барсан, шилжин явсан, бүртгэлийн зөрчилтэй иргэдийн мэдээллийг засварлаж 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр иргэний бүртгэлийн газарт илтгэх хуудсыг хүргүүлсэн.

### ТООН ГАРЫН ҮСЭГ:

Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн талаарх” сургалтыг 2 төрийн болон төрийн бус байгууллагын 63 албан хаагчдад хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Тайлант хугацаанд 3796 иргэнд тоон гарын үсэг олгосон.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 9567 бүртгэл бүртгэгдсэн. Үүнийг ангилбал:



### ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ:

Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 20 албан бичгээр 56 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, эрх сэргээх тухай 30 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 61 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээх бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажилласан.

“Монголын ипотекийн корпорац”-ийн 2025 оны 25/31 тоот албан бичгээр “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд /

ипотекийн зээл/ тусгагдсан 4 банкны 149 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 330 хуулийн этгээдийн лавлагаа хуулбарыг олгож ажилласан. УБЕГ-ын даргын 2023.08.24-ны өдрийн А/1614 тушаалын дагуу 10 газар, 39 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хаах бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажиллав.

УБЕГ-ын даргын 2020.08.11-ны өдрийн 8/7219, 2026.03.06-ны өдрийн 1164 тоот чиглэлийн дагуу ХУБ-ийн дүгнэлтээр үрэгдүүлсэн 50 газар 15 үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх гэрчилгээг хүчингүйд тооцож шинээр гэрчилгээг бичиж олгосон. УБЕГ-ын ХШГ-ын ХУАБайцаагчийн 2022.03.02-ны өдрийн № 1500, 2026.03.04-ний өдрийн дүгнэлтийг үндэслэн ЭХЭУБ-ийн 16 хувийн хэргийн цахим мэдээллийн санг архивын хувийн хэргийн цаасан нотлох баримттай тулган шалгаж мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулж, мэдээллийн санд баяжилт хийж ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 4/1857 дугаар, 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 4/2308 дугаар, 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 4/3053 дугаар, 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 4/3151 дугаар, 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 4/3860 дугаартай хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 4242 бүртгэлийг бүртгэсэн. Мөн 4 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг олгож 2026 онд нийт 149 бүртгэл хөтөлсөн.

#### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ:

Тайлант хугацаанд 500 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр ханган ХЭУБ-ийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд “Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хууль”-ийн дагуу 19.599 мян.төгрөгийн хураамжийг киоск машинаар улсын болон орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн актын хүрээнд дараах ажил үүргийг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- 164 аж ахуйн нэгж, байгууллага шинээр үүсгэн байгуулсан.
- 242 нэр төрлийн нэмэлт өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулж, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн /шилжиж ирсэн/ шалтгаанаар 29 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон.
- Хуулийн этгээдийн 4 салбар шинээр бүртгэсэн. Дорнод аймагт бүртгэлтэй 4 салбарт нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 6 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасаж татан буулган, хувийн хэргийг архивлан хэлтсийн архивд шилжүүлсэн. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр

өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 24 тамгыг хураан авсан.

- Архивын цахим мэдээллийн сангаас 5 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн этгээдэд лавлагаа /тодорхойлолт/ олгож ажилласан.
- 167 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн
- Төрийн үйлчилгээний систем болох ebusiness.mn сайтад хуулийн этгээдийн 1074 оноосон нэрийн хүсэлтийг мэдээллийн санд шүүж, хариуг хүргүүлж ажилласан.
- Тайлант хугацаанд хэлтсийн даргаас цохогдсон хууль хяналтын байгууллагын 13 албан бичигт хариуг хүргүүлж, УБЕГ-ын нэгдсэн архивд 19 аж ахуй нэгжийн хувийн хэрэг, мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэлийг албан бичгээр хүргүүлсэн.

Бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, иргэдийн цахим мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан бэлтгэсэн “Та үүнийг мэдэх үү?” цуврал видео контентын №12 дугаарт “Төрийн бус байгууллагын тайлан илгээх заавар”-ыг 3500 хүн үзэж, “Эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх” талаарх видео 1800 хүний үзэлттэй байна.

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран “Олон улсын тэргэнцэртэй иргэдийн өдөр”, “Дэлхийн сонсгол хамгаалах өдөр” –ийг тохиолдуулан зохион байгуулсан 2 удаагийн арга хэмжээнд тэргэнцэртэй, тулгуур эрхтэн болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөн, “Наран мандах бие даан амьдрах төв” нэртэй НҮТББайгууллагын бичиг баримтыг бэлтгэн өгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ гардуулсан. Тус “Гарт-Гэрт” буюу зөөврийн төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлсэн бүртгэлийн мэдээллээ бичлэг контент болгон байгууллагын цахим хуудсанд байршуулахад 2 удаагийн бичлэг нийт 5.5к үзэлттэй байна.

Аймгийн Жижиг дунд үйлдвэрийн газраас зарласан жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл, сум хөгжүүлэх сангийн зээл, аймгийн Засаг даргын Тамгын Газраас баталсан “Хүн болох багаасаа” төслийн хүрээнд төслийн тендер, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хуулийн этгээдүүдийг тендерийн материалаа нэг цэгээс бүрдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах “Нэг цэгийн үйлчилгээ”-нд тус тус ажиллаж, 56 аж ахуй нэгжийн бүрдүүлбэрийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэж ажилласан.

Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран жижиг дунд бизнес эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч иргэдэд зориулсан “Хуулийн этгээдийн шинээр үүсгэн байгуулахад шаардлагатай бүрдүүлбэр, нэмэлт өөрчлөлт”-ийн талаарх сургалтыг 110 иргэнд, Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран “Хүн болох багаасаа” төслийн хүрээнд төрийн бус байгууллагын тухай хууль, бүрдүүлбэрийн талаарх сургалтыг 79 иргэнд, “Хөдөөгийн эмэгтэйчүүд” ТББ-ын зохион байгуулсан Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдэд зориулсан сургалтыг 19 иргэнд тус тус мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.



Сумын улсын бүртгэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр танхимын сургалт зохион байгуулж, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл, чиглэл өгч ажилласан.



### АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын болон төрөлжсөн архивын чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган тасгийн даргаар хянуулж, хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн 200893 хувийн хэрэг ХААТР маягтууд хадгалагдаж, 2265 ширхэг ХААТР маягтыг иргэний улсын бүртгэгчээс хүлээн авч, архивын сан хөмрөгийн баяжуулалтыг хийсэн. Мөн хяналтын улсын байцаагч болон

улсын бүртгэгч нарт 54 ширхэг хувийн хэрэг татан өгч, 435 ширхэг бүртгэлийн дэвтрийн хуулбарыг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 48309 хувийн хэрэг хадгалагдаж байна. ЭХЭУБ хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон нэмэлт өөрчлөлтийн 3740 нотлох баримт, шинээр үүсгэсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 213 газраас бусад үл хөдлөх ЭХЭУБ 361 хувийн хэргийг архивд хүлээн авч байршуулсан. Мөн бүртгэлийн үйл явцад шалгах шаардлагатай 266 хувийн хэргийг улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч, хэлтсийн дарга, улсын бүртгэгчид хүлээлгэн өгсөн.

Газар болон газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 2375 ширхэг хувийн хэргийг архивын стандартын дагуу бор хайрцагт байршуулсан стандартын дагуу цэгцэлж ажилласан.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3474 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс шинээр үүссэн аж ахуй нэгжийн 157 ширхэг хувийн хэрэг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэсэн Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс шаардлага хангахгүй болон хэрэглэх боломжгүй болсон 34 тамгыг хүлээн авсан.



Хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримтад тусгагдсан тоотой тохирч буй эсгэхийг шалгах, механик болон биологийн гэмтлээс сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор хуулийн этгээдийн бүртгэлийн цаасан суурьтай эх нотлох баримтад тооллогыг 100 хувь хийж дууссан. Архивын тайлан мэдээг сар бүрийн 25-аар тасалбар болгон үнэн, зөв гаргаж холбогдох газарт хугацаанд хүргүүлэн ажилласан.

#### БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 1/29 албан даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Байгууллагын архивд ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл болон анхны тусламжийн иж бүрдлийг байршуулсан.
- Байгууллагын архивын баримтад тооллого явуулав.
- Баримт бичиг нягтлан шалгах комисс, хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг шинээр томилов.

- Албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлт болон үнэт цаастай холбоотой анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулж, холбогдох мэдээлэл, зөвлөмжөөр хангасан.
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2026 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчлэн батлав.



## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Тайлант хугацаанд 1,206,282,800 төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаа явуулж 498,965,100 төгрөгийн буюу 41,3% төсвийн гүйцэтгэлтэй ажилласан. Улсын төсөвт 119,678,395 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үнэт цаас зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд УБЕГ-ын Санхүү үйлчилгээний хэлтэст хүргүүлсэн.

Бараа материал худалдан авах зорилгоор 5 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан, худалдан авалтад 15,385,955 төгрөгийг зарцуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), байгууллагын [www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) сайтад 83 мэдээлэл байршуулж 48,5% хувийн гүйцэтгэлтэй ажилласан.


Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем шинээр нэвтэрч, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоолоор Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу 4 жилд 1 удаа зохион байгуулдаг. Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого 2026 онд тус системээр зохион байгуулах тул бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



### ӨРГӨДӨЛ ГОМДОЛ:

Өргөдөл гомдлыг нээлттэй утас 98-970-970, өргөдөл гомдлын дэвтэр, санал хүсэлтийн хайрцаг, цахим хуудсаар хүлээн авч ажиллаж байна. Бүртгэлийн үйлчилгээг ИУБ-ийн онлайн санд шалгуулаагүйгээс иргэд буруу төлбөр тушаах, интернэтийн хурднаас шалтгаалж киоск машин гацаж баримт хэвлэхгүй тохиолдолд дахин тушаах зэрэг зөрчил удаа дараа үүссэн тул зөвлөгөө өгөх бүртгэгч нарыг хуваарийн дагуу ажиллуулж байна.

Засгийн газрын 11-11 тусгай дугаарт албан хаагчтай холбоотой 1 гомдол, иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 79 өргөдлийг хүлээн авч тухай бүрд нь шийдвэрлэж хариу өгч ажилласан.



### СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Сургалтын ажлын хэсэг нь 2026 оны сургалтын төлөвлөгөөг 12 бүлэг, 16 заалттайгаар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Хөдөөгийн эмэгтэйчүүд” ТББ-аас зохион байгуулсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдэд зориулсан сургалт зөвлөгөө өгөх уулзалтад захиргааны ахлах мэргэжилтэн М.Галбадрах, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Ууганчимэг нар оролцож, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн үйлчилгээний талаар 24 иргэнд, Аймгийн Жижиг дунд үйлдвэрийн газраас зарласан жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл, сум хөгжүүлэх сангийн зээл, аймгийн Засаг даргын Тамгын Газраас баталсан “Хүн болох багаасаа” төслийн хүрээнд төслийн тендер, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хуулийн этгээдүүдийг тендерийн материалаа нэг цэгээс бүрдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах “Нэг цэгийн үйлчилгээ”-нд хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Ууганчимэг тус тус ажиллаж, 110 орчим иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, 47 аж ахуй нэгжийн бүрдүүлбэрийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэж ажилласан. Олон улсын тэргэнцэртэй иргэдийн эрхийн өдөр (03 дугаар сарын 01), “Дэлхийн сонголт хамгаалах өдөр”-ийг (03 дугаар сарын 03) тохиолдуулан Дорнод аймаг дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-тэй хамтран тусгай хэрэгцээт 54 иргэнд

иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн сургалт хийн зөвлөгөө, мэдээллийг өгч, 21 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн тоног төхөөрөмжөөр хүргэж ажиллав.



Баяндун сумын улсын бүртгэгч Ч.Долгормаа нь "Хүнс хөдөө аж ахуйн салбарын мэргэжил сурталчлах" аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 120 сурагчдад иргэний үнэмлэх захиалахад анхаарах асуудал, Хоршооны 26 гишүүдэд хуулийн этгээдийн өөрчлөлтийн бүртгэл болох гишүүн нэмэх, хасах, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, үйл ажиллагааны чиглэл хэрхэн нэмүүлэх талаар мэдээлэл өгч ажилласан.



Тайлант хугацаанд нийт 23 сургалтад давхардсан тоогоор 346 албан хаагч хамрагдсан. Үүнээс:

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан мэргэшил арга зүйгээр хангах, ур чадварыг нэмэгдүүлэх, арга зүйн 8 удаагийн онлайн сургалтад (бүртгэлийн чиглэлээр-7, бусад-1), танхимын 3 удаагийн сургалтад (Удирдах ажилтны зөвлөгөөн, Захиргааны ахлах мэргэжилтнүүдийг дадлагажуулах, чиглүүлэх сургалт, Захиргааны ахлах мэргэжилтэн Авлигатай тэмцэх газарт "Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх" сургалт) хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан болон хамтарсан 12 төрлийн сургалтад албан хаагчдыг хамруулсан.

Төрийн албаны зөвлөлийн /7:4:10/ 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 360 албан хаагч хамрагдсан.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан мэргэшил арга зүйгээр хангах, ур чадварыг нэмэгдүүлэх, арга зүйн сургалтуудад хамрагдлаа. Үүнд:

- Тус хэлтэст шинээр томилогдсон 1 албан хаагчийг чиглүүлэх, ажлын байранд дадлагажуулах сургалт;
- Захиргааны ахлах мэргэжилтнүүдийг дадлагажуулах, чиглүүлэх сургалт;
- Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн;




Аймгийн тагнуулын газраас төрийн нууц болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаар сургалт зохион байгуулж сургалтад хэлтсийн 17 албан хаагч хамрагдсан.



Хэлтсийн албан хаагчид аймгийн Төв номын сангийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцаж шинэ уншигчийн карт нээлгэлээ.

Албан хаагчдыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, гар утасны хэрэглээг үр дүнтэй ашиглах, цахим уншлага, сонсдог номтой нөхөрлөхийг уриалав.



Аймгийн ЗДТГазрын ёс зүйн дэд хорооны гишүүн Э.Отгончимэг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чадавхжуулах зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт хийв. Сургалтад хэлтсийн 25 албан хаагч хамрагдсан.



"Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн дэлхийн өдөр"-ийг тохиолдуулан 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр аймгийн Улаан загалмайн хорооноос анхны тусламжийн мэдлэг олгох сургалтыг авч, сургалтад хэлтсийн 11 албан хаагч хамрагдлаа. Албан хаагчид болзошгүй гэмтэл, бэртэл, аюул ослын үед өөртөө болон бусдад эрүүл мэндийн анхны тусламжийг шуурхай, зөв үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшив. Сургалтын хүрээнд оролцогчид амь насыг авран хамгаалах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга барилд суралцаж, анхны тусламжийн багц, тоног төхөөрөмж, манекен ашиглан практик дадлага хийв.



Авлигатай тэмцэх ерөнхий газраас 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг

хүлээн авах, хянах, цахим системд орж буй өөрчлөлт хариу хүргүүлэх талаарх сургалтад хэлтсийн дарга хамрагдсан.

Аймгийн хүний эрхийн асуудал хариуцсан референт Б.Дугарсүрэн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Жендерийн эрх тэгш байдал” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад хэлтсийн 14 албан хаагч хамрагдлаа.



Ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх сургалтыг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх төвийн сэтгэл зүйч С.Бадамханд хэлтсийн албан хаагчдад зохион байгуулсан.

Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумын улсын бүртгэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр танхимаар зохион байгууллаа.



Аймгийн Татварын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 2026.05.07-ны өдөр иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Нэг өдөр–Нэгдсэн үйлчилгээ” өдөрлөгийг “ТАНА” худалдааны төвийн гадна талбайд зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт 39 иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсгийг ашиглах заавар, хэрэглээний талаар мэдээлэл өгсөн.



Тэрбум бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Байгаль орчны газартай хамтран 5 сард шинээр мэндэлсэн үрс болон гэр бүл болж буй хосуудад 3 настай нарс мод, Хас банкны Ирээдүйн саятан хадгаламжийн 100.000 төгрөгийн эрхийн хамтаар бэлэглэж ажилласан.



Олон улсын гэр бүлийн өдрийг угтан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран “ХАЙР ДҮҮРЭН ГЭР БҮЛ” өдөрлөгийг халуун дулаан, дурсамж дүүрэн уур амьсгалтайгаар зохион байгуулагдав.

Өдөрлөгт тус хэлтсийн Цагаан-Овоо сумын улсын бүртгэгч А.Гэрэлцогт, Чойбалсан сумын улсын бүртгэгч Б.Ганцацрал нар гэр бүлийн хамт оролцлоо.



Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Баяндун сумын улсын бүртгэгч Ч.Долгормаа сумын ЗДТГ-тай хамтран “ХАЙР ДҮҮРЭН ГЭР БҮЛ” өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр гэр бүлүүд урт удаан хугацаанд аз жаргалтай хамтдаа амьдрахын бэлгэдэл болгон нарс мод тарьж, халуун дулаан харилцаа, дурсамж бүтээсэн уур амьсгал дунд өрнөж, оролцогчдод баяр баясал дүүрэн сайхан өдөр болж өнгөрлөө.



2025 оны улирал бүр зохион байгуулагддаг “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу шалгалтад оролцогч иргэдийн бүртгэлийг хурууны хээгээр бүртгэж ажиллалаа.




Баяндун, Дашбалбар сумдад 2026.04.15, 22-ны өдрүүдэд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж өдөрлөгийн хүрээнд 280 гаруй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, 53 иргэний эд хөрөнгийн эрхийн гэрчилгээг гарган ажилласан.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2026 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ерөнхий хяналтын сонсгол”-ын ажлын хэсэгт Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Ж.Ганзориг оролцов.
- Аймгийн “Хүний эрхийн салбар зөвлөл” ажлын хэсэгт хэлтсийн дарга Д.Оюунбаяр ажиллаж байна.
- “Аж ахуй нэгж, байгууллагын тооллого-2026” тооллогын аймгийн болон сумын ажлын хэсэгт хэлтсийн дарга, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга нар оролцов.
- Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр танилцуулсан.
- “НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233” дугаарын утас, “Иргэд хүлээн авах төв”-д аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, газар, хэлтсийн удирдах ажилтнууд 7 хоног бүрийн Пүрэв гарагт баталсан хуваарийн дагуу ажиллаж байна.



 **Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар** ...  
March 19 · 🌐

✅ **НЭЭЛТТЭЙ УТАС -70582233 ДУГААРТ ИРГЭД АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААС ИРЭХ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА**

“НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233” дугаарын утас, “Иргэд хүлээн авах төв”-д аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, газар, хэлтсийн удирдах ажилтнууд 7 хоног бүрийн Пүрэв гарагт баталсан хуваарийн дагуу ажиллаж байна.

Өнөөдөр буюу 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр ажиллаж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч байн... [See more](#)

## ИРГЭДЭД ЗӨӨВРИЙН ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЛЭЭ.


Зорилтод бүлгийн 15 иргэдийн гэрт очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Олон улсын тэргэнцэртэй иргэдийн эрхийн өдөр (03 дугаар сарын 01),



“Дэлхийн сонсгол хамгаалах өдөр”-ийг (03 дугаар сарын 03) тохиолдуулан Дорнод аймаг дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-тэй хамтран тусгай хэрэгцээт 21 иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн тоног төхөөрөмжөөр хүргэж ажиллав.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дугаар харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тусгай тэмдэг, тэмдэглэгээ бүхий үйлчилгээний цонх бий болгон, бүртгэл хөтлөн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 9 иргэн үйлчлүүлсэн. Иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй болон тусламж шаардлагатай иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын гадна талд “Тусламжийн хонх”-ыг байршуулав. Ингэснээр бүртгэлийн үйлчилгээ авах иргэд шаардлагатай үед байгууллагын ажилтнаас түргэн шуурхай тусламж, мэдээлэл авах нөхцөл боломж бүрдсэн.



## НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.


Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Татварын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Нэг өдөр–Нэгдсэн үйлчилгээ” өдөрлөгийг “ТАНА” худалдааны төвийн гадна талбайд зохион байгууллаа.

“Нэг өдөр – Нэгдсэн үйлчилгээ” өдөрлөгийн үеэр нийт 39 иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсгийг ашиглах заавар, хэрэглээний талаар мэдээлэл өгч ажиллалаа.




“Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Хуульчийн про боно өдөр-2026” арга хэмжээ 2026 оны 4 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж өдөрлөгөөр 426 иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. Үүнд:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр – 274
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр - 138
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр – 14



## ЭРҮҮЛ МЭНД:

Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хэлтсийн албан хаагчдыг улаанбурханы эсрэг вакцинд хамруулсан



## БУСАД:

Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дуут дохиогоор дадлага сургуулилалтад хамрагдсан.

Сургуулилтад Нутгийн удирдлагын ордонд үйл ажиллагаа явуулдаг төрийг байгууллагуудын алба хаагч нар оролцож, гамшгийн үед ажиллах бэлэн байдлаа ханган, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэв.



Ус, цаг уурын байгууллагын 90 жилийн ойн нэрэмжит спортын олон төрөлт тэмцээнд баг, хамт олноороо амжилттай оролцсон.



Хэрлэн сумын 1 дүгээр багт байгууллагын “Ногоон төгөл”-ийг 2014 онд байгуулж, арчилгаа, хамгаалалтын ажлыг жил бүр тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Ногоон байгууламжийн нөхөн сэргээлт, мод бутны ургалтыг дэмжих зорилгоор 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр албан хаагчид гэр бүлийн хамт оролцож, хатаж үхсэн 12 ширхэг нарс моддыг нөхөн сэргээж шинээр тарин, төглийн мод бутанд усалгаа, арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж ажилласан.



“Идэвхтэй насжилт-дасгал хөдөлгөөн” улирлын аяны нээлтэд оролцлоо.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Эрүүл мэндийн яам, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Биеийн тамир, спортын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран “Идэвхтэй насжилт-дасгал хөдөлгөөн” улирлын аяны нээлтэд байгууллага хамт олноороо оролцов.



Сар шинийг угтан “Бидний өв соёл – Бидний бахархал” сэдэвт үндэсний уламжлалт шагайн наадгайг албан хаагчдын хүүхдүүдийн дунд зохион байгуулж, үндэсний өв соёл, ёс заншлаа хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд албан хаагчдын 12 хүүхэд оролцож, хүүхдүүд шагайн харваа, няслах зэрэг уламжлалт тоглоомоор өрсөлдөн, авхаалж самбаа, хурд хүчээ сорин, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэв.






Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхэд зөв хүн болж төлөвшихөд чиглэсэн нөлөөллийн ажлын хүрээнд хүүхдүүдтэйгээ цээнэ, лили, мандарваа, унтаахай зэрэг олон төрлийн цэцгийн үрсэлгээг суулгаж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үйлсэд идэвхтэй оролцлоо.



“Хүүхэд бүрд хайр” аяны хүрээнд “Warm family day” өдөрлөг зохион байгуулав. Энэхүү өдөрлөгт эцэг эх, хүүхдүүд хамтдаа бялуу чимэглэж, цэцэг боон, сэтгэлийн халуун дулаан үгс бүхий захидал солилцон, инээд хөөр, аз жаргалаар дүүрэн дурсамжийг хамтдаа бүтээлээ. Гэр бүлийн үнэ цэнэ, хайр халамжийг илэрхийлсэн энэ өдөр хүн бүрийн сэтгэлд дулаан мэдрэмж үлдээж, хүүхэд бүр хайр энэрэл дунд өсөхийн чухлыг сануулсан арга хэмжээ боллоо.



Хэрлэн сумын Засаг даргын 2026 оны А/100 дугаар захирамжаар сар бүрийн сүүлийн долоо хоногийн пүрэв гарагийг “Бүх нийтийн цэвэрлэгээ”-ний өдөр болгон зарласантай холбогдуулан тус хэлтсийн албан хаагчид нийтийн эзэмшлийн зам, талбай болон эргэн тойрны 50 метр хүртэлх хог, шороог цэвэрлэн ажиллаж байна.



Аймгийн төрийн байгууллагуудын дэргэдэх “ШИЛДЭГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-өөр 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр шалгарав.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАЛБАДРАХ